



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/191

Улаанбаатар хот

Эм, эмнэлгийн хэрэгсэлд олгох импорт,
экспортын лицензийн хүсэлтийг цахимаар хүлээн
авах үйл ажиллагааг эхлүүлэх тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 8.1, 8.5, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эм, эмнэлгийн хэрэгсэлд импортын лиценз олгох журам” А/407 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгсэлд олгох импорт, экспортын лицензийн хүсэлтийг Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн E-Mongolia системээр <https://e-mongolia.mn/> хүлээн авч, шийдвэрлэх үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд туршилтын журмаар хэрэгжүүлсүгэй.

2. Эм, эмнэлгийн хэрэгсэлд олгох импорт, экспортын лицензийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Эм, эмнэлгийн хэрэгсэлд олгох импорт, экспортын лицензийн хүсэлтийг цахимаар авах үйл ажиллагааг туршилтын хугацаанд хэрэгжүүлж холбогдох нэмэлт өөрчлөлтийг хийн үргэлжүүлэн ашиглаж явцын тайланг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан удирдлагын зөвлөлд танилцуулахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Л.Зэндмаа)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422

01191

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 17/191 дугаар тушаалын хавсралт

ИМПОРТ, ЭКСПОРТЫН ЛИЦЕНЗИЙН ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР ХҮЛЭЭН АВЧ, ШИЙДВЭРЛЭХ, МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах мэргэжилтэн
1	Ханган нийлүүлэх байгууллагуудад танилцуулга, сургалт зохион байгуулах	2022 оны 10 дугаар сарын 21	Б.Амарсанаа
2	Холбогдох мэдээлэл, сурталчилгааг бэлтгэн байгууллагын цахим хаягт байршуулах	2022 оны 10 дугаар сарын 19	Б.Амарсанаа
3	Импорт, экспортын лицензийн хүсэлтийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч туршилтын үйл ажиллагааг эхлүүлж, хууль журмын дагуу шийдвэрлэх	2022 оны 10 -11 дүгээр сар	Б.Амарсанаа, А.Номиндарь, Н.Галзул
4	Ханган нийлүүлэх байгууллага, мэргэжилтэнгүүдэд програм ашиглалтын талаар заавар зөвлөгөөг өгч, саналыг тусган бүртгэх	2022 оны 10-11 дүгээр сар	Б.Амарсанаа, А.Номиндарь, Н.Галзул
5	E-mongolia УТҮГ-д программын шинэчлэлт, өөрчлөлт оруулах талаар саналыг хүргүүлэх	2022 оны 11 дүгээр сар	ЛЗЗГ
6	Импорт, экспортын лицензийн хүсэлтийн цахим үйл ажиллагааг тогтмолжуулах, ил тод шуурхай байдлыг ханган ажиллаж, үр дүнг даргын зөвлөлийн хуралд танилцуулах	2022 оны 12 дугаар сар	ЛЗЗГ

--ooOOoo--